



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/245.

Ховд

Төрийн үйлчилгээний талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1." а" дахь заалт, Засгийн газрын "Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 149 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан "Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Нутгийн удирдлагын ордонд үйл ажиллагаа явуулж буй "Нэг цонхны үйлчилгээ"-ний төвийг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн "Үйлчилгээний нэгдсэн төв" болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Жаргалант сумын Нутгийн удирдлагын ордонд "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийг холбогдох журмын дагуу ажиллуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/-т нарт даалгасугай.

3. Жаргалант сумын "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийг журамд заасан бүтэц, орон тоогоор болон бусад сумдад үйлчилгээний оператор ажиллуулахад шаардагдах төсвийг аймгийн 2022 оны төсөвт суулгаж, санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/275-Bo